



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 8/405

Улаанбаатар хот

Г Үйлчлүүлэх албан тушаалтны жагсаалт,
үйлчлэх хүрээ, тусlamж, үйлчилгээний
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлгээр үйлчлүүлэх албан тушаалтны жагсаалт, үйлчлэх хүрээ, тусlamж, үйлчилгээний чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Үйлчлэх хүрээний албан тушаалтны судалгааг гарган жил бүр шинэчлэн зөвшөөрөл олгож эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд хамруулж байхыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга (С.Энхболд)-д даалгасугай
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар (Я.Буянжаргал), Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус даалгасугай.
4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйлчлэх хүрээ шинэчлэгдсэнтэй холбоотой эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах хөтөлбөрийг лавлагаа төвүүдтэй хамтран хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д даалгасугай.
5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 161, 364 дүгээр тушаал, 2014 оны 06 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.



141201451

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08
дугаар сарын 11... өдрийн 09 дугаар
тушаалтын хавсралт

**Улсын хоёрдугаар төв эмнэлгээр үйлчлүүлэх албан тушаалтны жагсаалт,
үйлчлэх хүрээ, тусlamж, үйлчилгээний чиглэл**

Нэг. Үйлчлүүлэх албан тушаалтын жагсаалт

- 1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч;
- 1.2. Монгол Улсын Их Хурлын дарга,
- 1.3. Монгол Улсын Ерөнхий сайд;
- 1.4. Монгол Улсын Их Хурлын дэд дарга;
- 1.5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга,
- 1.6. Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч;
- 1.7. Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн,
Монгол Улсын сайд;
- 1.8. Монгол Улсын Ерөнхий прокурор;
- 1.9. Монгол Улсын Ерөнхий аудитор;
- 1.10. Авилгатай тэмцэх газрын дарга;
- 1.11. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга;
- 1.12. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
- 1.13. Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- 1.14. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын дээд
шүүхийн шүүгч;
- 1.15. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- 1.16. Монгол банкны Ерөнхийлөгч,
- 1.17. Санхүүгийн зохицуулах хорооны дарга;
- 1.18. Үндэсний статистикийн газрын дарга;
- 1.19. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга;
- 1.20. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга;
- 1.21. Аймгийн Засаг дарга;
- 1.22. Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч;
- 1.23. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга;
- 1.24. Сонгуулийн ерөнхий хорооны дарга;
- 1.25. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга,
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;
- 1.26. Авилгатай тэмцэх газрын дэд дарга;
- 1.27. Дэд сайд;
- 1.28. Ерөнхийлөгчийн зөвлөх, Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий
сайдын зөвлөх;
- 1.29. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга;
- 1.30. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн;
- 1.31. Монгол банкны дэд ерөнхийлөгч;
- 1.32. Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч;

- 1.33. Үндэсний статистикийн газрын дэд дарга;
- 1.34. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний Комиссын гишүүн, Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга.

Хоёр. Төрийн захиргааны албан тушаалтан

- 2.1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тамгын газар, ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалтан;
- 2.2. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга;
- 2.3. Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агетлагийн дарга, дэд дарга, газрын дарга.

Гурав. Тусгай албан тушаалтан

- 3.1. Аймаг, нийслэлийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор;
- 3.2. Төрийн тусгай хамгаалалтын дарга, орлогч, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын хамгаалалтын албан хаагчид;
- 3.3. Монгол банкны захирлууд, газрын дарга нар;
- 3.4. Төрийн ордны хамгаалалтын албаны дарга;
- 3.5. Авилгатай тэмцэх газрын хэлтэс, албаны дарга;
- 3.6. Үндэсний Аудитын газрын дарга, аудитор;
- 3.7. Аймаг, нийслэлийн Ерөнхий аудитор.

Дөрөв. Бусад иргэд

- 4.1. Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон, гавьяат цолтон, Төрийн соёрхолтон;
- 4.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгодог генерал, онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, хууль цаазын жинхэнэ зөвлөх цолтон;
- 4.3. Монгол Улсаас гадаад улс, НҮБ-ын төрөлжсөн байгууллагад суугаа бүрэн эрхт элчин төлөөлөгчийн газрын дипломат ажилтан /эх орондоо ирсэн үедээ/;
- 4.4. Гадаад орнуудаас Монгол Улсад суугаа дипломат ажилтан, олон улсын байгууллагын төлөөлөгч, гадаадын зочин төлөөлөгчид, мэргэжилтэн, иргэн;
- 4.5. ШУА-ийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, орлогч дарга, эрдэмтэн нарийн бичгийн дарга, академич, шинжлэх ухааны докторууд (Dr.Sc);
- 4.6. УИХ-д суудалтай намын дарга, дэд дарга, ерөнхий нарийн бичгийн дарга;
- 4.7. Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан “Төрийн өндөр албан тушаалтын зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтын зэрэглэл-д заагдсан албан тушаалыг эрхэлж байсан, чөлөөнд буюу гавьяаны амралтад гарсан хүн;
- 4.8. 1990-1992 оны АИХ-ын депутат, Улсын Бага хурлын гишүүн;
- 4.9. Монгол Улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн даргын ажлын албаны ажилтан;

- 4.10. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга, Нийслэлийн Засаг даргын орлогч, Хотын Ерөнхий менежер, Тамгын газрын дарга, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч;
- 4.11. Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн;
- 4.12. 1939, 1945 оны дайн, 1947 оны баруун хилийн тулаанд оролцсон ахмад дайчин;
- 4.13. Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт ажиллаж байгаад гавьяаны амралтад гарсан хүмүүс, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;
- 4.14. Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан цол тэмдэгтэн;
- 4.15. Эрүүл мэндийн яамны аппаратын болон гэрээт ажилтнууд, тус яаманд ажиллаж байгаад гавьяаны амралтад гарсан хүн.

Тав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдах хугацаа

- 5.1. Энэхүү тушаалын хавсралтын нэгдүгээр хэсгийн 1.1-1.5-д заагдсан албан тушаалтнуудын эхнэр/нөхөр, 16 хүртэлх насын хүүхэд хугацаагүй үйлчлүүлнэ.
- 5.2. Энэ тушаалын хавсралтын 1.6-1.33 болон хоёрдугаар хэсэгт заагдсан албан тушаалтнууд, тэдний гэр бүл, 16 хүртэл насын хүүхэд нь тухайн албан тушаалыг эрхэлж байх үедээ үйлчлүүлнэ.
- 5.3. Энэ тушаалын хавсралтын дөрөв дэх хэсгийн 4.1, 4.2, 4.8-д заагдсан иргэд, гэр бүл, 16 хүртэл насын хүүхдийн хамт үйлчлүүлнэ.
- 5.4. Энэ тушаалын 5.3-д заасан иргэд нас барсан тохиолдолд тэдний гэр бүлийн гишүүдийг 1 жилийн хугацаанд үргэлжлүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлээд нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу өрх, дүүргийн эмнэлэгт шилжүүлнэ.

Зургаа. Эмнэлгийн үйлчлэх хүрээ, тусламж, үйлчилгээний чиглэл

- 6.1. Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр аймаг, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн хүн амд эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 6.2. Нийслэлийн Баянзүрх, Багануур, Налайх, Багахангай дүүргийн хүн амд мэс заслаас бусад эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 6.3. Энэ тушаалын нэгдүгээр хэсэгт заасан албан тушаалтнуудад эрүүл мэндийн анхан болон эмнэлгийн лавлагаа, бусад үйлчлэх албан тушаалтанд эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж үзүүлнэ.